



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/29

Хэрлэн сум


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.17, 65 дугаар зүйлийн 65.1.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан журмын 2.3 дахь заалт, Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн 1.5.3-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх” ажлын хүрээнд байгаль орчинд ээлтэй хандах хандлагыг төлөвшүүлж, зөв дадлыг хэвшүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон цаасан урлал сонирхогч иргэдийн дунд зарласан “Бид бүтээгчид” хаягдал цаас ашиглан бүтээл хийх уралдааныг зохион байгуулахад “Хэнтий мэдээ” сонины газарт санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Дэмжлэгт шаардагдах 400.000 /дөрвөн зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын тэтгэмж урамшууллын зардлаас олгохыг Санхүү төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 243